



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Иххэт сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2021/40/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Сайншанд

2021 он

Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 7052-2734 Цахим хаяг: Gan-ulzii.t@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 7052-3020 Цахим хаяг: Oyuntulkhuur.u@audit.gov.mn

Ахлах аудитор: Ч.Ариунаа

Утас: 7052-3020 Цахим хаяг: Ariunaa.ch@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СБТ	Санхүүгийн байдлын тайлан
ДГА	Дорноговь аймаг
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНТ	Орон нутгийн төсөв
БГБНАҮТХ	Бусдаар гүйцэтгүүлэх бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1.Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2.Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3.Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4.Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5.Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6.Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	13
3.Аудитын тайлан	14
3.1.Ерөнхий зүйл	12
3.2.Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	14
3.3.Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	15
3.4.Материаллаг байдал	15
3.5.Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	15
3.6.Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	16
3.7.Шилэн дансны мэдээлэл	17
3.8.Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.9.Аудитын илрүүлэлт	18
Залруулсан алдаа	18
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	18
Аудитын зөвлөмж	18
3.10.Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	18
4.Менежментийн захидал	19
5.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20

1.Төрийн аудитын санал, дүгнэлт



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021.02.25 № 1-6/131

танай _____-ны № _____-т

ИХХЭТ СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Н.ГАНТОГТОХ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Иххэт сумын Засаг даргын тамгын газрын дарга 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Иххэт сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Т.ГАН-ӨЛЗИЙ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	40,110,300.85	52,934,192.85
33	АВЛАГА	14,434,675.00	19,700,373.00
335	Бусад авлага	14,434,675.00	19,700,373.00
3351	Байгууллагаас авах авлага	14,434,675.00	19,700,373.00
35	БАРАА МАТЕРИАЛ	25,675,625.85	33,233,819.85
351	Түүхий эд материал	7,110,452.62	7,110,452.62
35110	Тусгай зориулалттай материал	7,110,452.62	7,110,452.62
354	Хангамжийн материал	18,565,173.23	26,123,367.23
35410	Бичиг хэргийн материал	2,163,860.00	2,079,380.00
35420	Аж ахуйн материал	12,791,413.23	17,066,187.23
35430	Сэлбэг хэрэгсэл	-	2,892,000.00
35470	Бусад хангамжийн материал	3,609,900.00	4,085,800.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,555,692,738.80	1,681,572,655.74
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,555,692,738.80	1,681,572,655.74
392	Биет хөрөнгө	1,482,595,238.80	1,605,830,780.74
39201	Барилга, байгууламж, орон сууц	993,975,679.00	1,135,866,364.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(34,748,542.89)	(69,344,894.21)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	299,877,500.00	334,287,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(228,058,866.74)	(258,083,661.04)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	114,797,972.58	141,610,612.58
39206	Хуримтлагдсан элэгдэл	(72,376,949.41)	(84,778,328.21)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	79,370,525.40	91,400,525.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(52,689,675.00)	(58,014,495.21)
39214	Бусад үндсэн хөрөнгө	744,190,735.80	796,484,369.80
39215	Хуримтлагдсан элэгдэл	(361,743,139.94)	(423,597,212.37)
393	Биет бус хөрөнгө	73,097,500.00	75,741,875.00
39301	Програм хангамж	3,405,000.00	6,641,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,113,500.00)	(3,705,125.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	72,806,000.00	72,806,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,595,803,039.65	1,734,506,848.59
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	25,000.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	25,000.00
413	Өглөг	-	25,000.00
4136	Бусад өглөг	-	25,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	25,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,595,803,039.65	1,734,481,848.59
51	Засгийн газрын хувь оролцоо	1,595,803,039.65	1,734,481,848.59
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	942,714,114.56	942,714,114.56
51101	Өмч: - төрийн	942,714,114.56	942,714,114.56
512	Хуримтлагдсан үр дүн	110,159,564.61	248,838,373.55
51210	Өмнөх үеийн үр дүн	110,159,564.61	110,159,564.61
51220	Тайлант үеийн үр дүн	-	138,678,808.94
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	542,929,360.48	542,929,360.48
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,595,803,039.65	1,734,506,848.59

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	685,004,500.00	655,489,795.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	299,864,199.00	278,532,825.00
120	Нийтлэг татварын бус орлого	299,864,199.00	278,532,825.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	298,705,422.00	1,272,192.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,272,192.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	298,705,422.00	-
120005	Түрээсийн орлого	1,158,777.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө		262,680,633.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал		14,580,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	385,140,301.00	376,956,970.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	65,064,501.00	35,056,864.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,250,000.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	61,814,501.00	35,056,864.00
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	320,075,800.00	341,900,106.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	320,075,800.00	341,900,106.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	510,320,398.74	516,810,986.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	510,320,398.74	504,155,986.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	507,237,854.35	502,704,414.37
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	170,610,990.00	197,834,771.24
210101	Үндсэн цалин	170,360,990.00	197,834,771.24
210104	Урамшуулал	250,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,309,147.00	24,297,791.07
210201	Тэтгэврийн даатгал	14,773,830.00	16,778,091.73
210202	Тэтгэмжийн даатгал	1,738,012.00	1,973,893.73
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,364,233.00	1,579,115.00
210204	Ажилгүйдлийн даатгал	312,097.00	360,616.35
210205	Эрүүл мэндийн даатгал	3,120,975.00	3,606,074.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,763,284.00	67,127,379.00
210301	Гэрэл, цахилгаан	3,298,884.00	3,202,979.00
210302	Түлш, халаалт	45,752,600.00	61,672,600.00
210303	Цэвэр, бохир ус	1,711,800.00	2,251,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,963,042.22	34,113,649.00
210401	Бичиг хэрэг	2,791,240.00	3,061,380.00
210402	Тээвэр, шатахуун	19,322,904.22	22,242,894.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,489,218.00	3,356,525.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	996,000.00	5,082,850.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	370,000.00
210408	Бараа материал акталсны зардал	1,363,680.00	-
2105	Нормативт зардал	200,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	200,000.00	-

Иххэт сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,776,000.00	774,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,300,000.00	-
210604	Урсгал засвар	476,000.00	774,700.00
2107	Томилолт, зочны зардал	12,527,646.00	2,885,500.00
210702	Дотоод албан томилолт	12,527,646.00	2,885,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,599,284.00	26,035,682.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	18,716,104.00	25,450,972.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	228,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	148,680.00	163,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	354,500.00	76,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	70,000.00	-
210807	Газрын төлбөр	150,000.00	117,360.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	196,488,461.13	149,634,942.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	49,519,676.00	4,841,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	700,000.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	146,268,785.13	144,793,042.06
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,082,544.39	1,451,571.69
2132	Бусад урсгал шилжүүлэг	800,000.00	800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	800,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,282,544.39	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,282,544.39	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	651,571.69
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	651,571.69
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	12,655,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	12,655,000.00
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал-Бараа материал	-	12,655,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	174,684,101.26	138,678,808.94
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	21,525,000.00	-
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	21,525,000.00	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(21,525,000.00)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	153,159,101.26	138,678,808.94

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	386,299,078.00	392,663,837.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,158,777.00	1,272,192.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,158,777.00	1,272,192.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	1,272,192.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	1,272,192.00
120005	Түрээсийн орлого	1,158,777.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	385,140,301.00	391,391,645.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	65,064,501.00	49,491,539.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,250,000.00	-

Иххэт сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	61,814,501.00	49,491,539.00
131106	Төсвийн урамшуулал		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	320,075,800.00	341,900,106.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	320,075,800.00	341,900,106.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	378,253,078.00	383,156,837.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	378,253,078.00	383,156,837.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	374,900,333.61	365,457,892.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	170,429,000.00	197,834,771.24
210101	Үндсэн цалин	170,179,000.00	197,834,771.24
210104	Урамшуулал	250,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,428,137.00	24,297,791.07
210201	Тэтгэврийн даатгал	14,896,055.00	16,778,096.86
210202	Тэтгэмжийн даатгал	1,737,264.00	1,973,896.04
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,363,571.00	1,579,115.80
210204	Ажилгүйдлийн даатгал	311,931.00	360,607.89
210205	Эрүүл мэндийн даатгал	3,119,316.00	3,606,074.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,763,284.00	67,127,379.00
210301	Гэрэл, цахилгаан	3,298,884.00	3,202,979.00
210302	Түлш, халаалт	45,752,600.00	61,672,600.00
210303	Цэвэр, бохир ус	1,711,800.00	2,251,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	36,947,406.61	20,298,369.00
210401	Бичиг хэрэг	3,447,800.00	2,942,800.00
210402	Тээвэр, шатахуун	27,596,778.61	12,632,794.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,702,828.00	3,619,525.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,200,000.00	1,103,250.00
2105	Нормативт зардал	200,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	200,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,054,000.00	6,005,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,884,000.00	4,771,500.00
210602	Тавилга	-	675,000.00
210604	Урсгал засвар	3,170,000.00	559,000.00
2107	Томилолт, зочны зардал	12,527,646.00	2,885,500.00
210702	Дотоод албан томилолт	12,527,646.00	2,885,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,577,684.00	42,008,582.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,694,504.00	41,386,872.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	228,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	148,680.00	163,350.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	354,500.00	76,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	70,000.00	37,000.00
210807	Газрын төлбөр	150,000.00	117,360.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	49,973,176.00	5,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	49,015,676.00	5,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	957,500.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,352,744.39	17,698,944.69
2132	Бусад урсгал шилжүүлэг	800,000.00	800,000.00

Иххэт сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	800,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,552,744.39	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,552,744.39	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	16,898,944.69
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	651,571.69
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		16,247,373.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	8,046,000.00	9,507,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	8,046,000.00	9,507,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	8,046,000.00	9,507,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	8,046,000.00	9,507,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	8,046,000.00	9,507,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(8,046,000.00)	(9,507,000.00)
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	942,714,114.56	542,929,360.48	25,000.00	1,485,668,475.04
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	110,159,564.61	110,159,564.61
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	942,714,114.56	542,929,360.48	110,184,564.61	1,595,828,039.65
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	942,714,114.56	542,929,360.48	110,184,564.61	1,595,828,039.65
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	942,714,114.56	542,929,360.48	110,184,564.61	1,595,828,039.65
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	138,678,808.94	138,678,808.94
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	942,714,114.56	542,929,360.48	248,863,373.55	1,734,506,848.59

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	351,092,700.00	342,520,726.31	8,571,973.69	0.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	351,092,700.00	342,520,726.31	8,571,973.69	0.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	350,292,700.00	341,720,726.31	8,571,973.69	0.98
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	198,233,400.00	197,834,771.24	398,628.76	1.00
210101	Үндсэн цалин	198,233,400.00	197,834,771.24	398,628.76	1.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,727,400.00	24,297,791.07	1,429,608.93	0.94
210201	Тэтгэврийн даатгал	17,494,700.00	16,778,096.86	716,603.14	0.96
210202	Тэтгэмжийн даатгал	2,058,200.00	1,973,896.04	84,303.96	0.96
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,646,600.00	1,579,115.80	67,484.20	0.96
210204	Ажилгүйдлийн даатгал	411,500.00	360,607.89	50,892.11	0.88
210205	Эрүүл мэндийн даатгал	4,116,400.00	3,606,074.48	510,325.52	0.88
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	67,291,700.00	67,127,379.00	164,321.00	1.00
210301	Гэрэл, цахилгаан	3,367,300.00	3,202,979.00	164,321.00	0.95
210302	Түлш, халаалт	61,672,600.00	61,672,600.00	-	1.00
210303	Цэвэр, бохир ус	2,251,800.00	2,251,800.00	-	1.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,226,900.00	16,974,275.00	1,252,625.00	0.93
210401	Бичиг хэрэг	3,300,800.00	2,887,800.00	413,000.00	0.87
210402	Тээвэр, шатахуун	9,524,100.00	9,463,700.00	60,400.00	0.99
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,282,000.00	3,519,525.00	762,475.00	0.82
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,120,000.00	1,103,250.00	16,750.00	0.99
2105	Нормативт зардал	200,000.00	-	200,000.00	0.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	200,000.00	-	200,000.00	0.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,180,000.00	12,173,500.00	3,006,500.00	0.80
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	4,999,500.00	500.00	1.00
210602	Тавилга	8,600,000.00	6,615,000.00	1,985,000.00	0.77
210604	Урсгал засвар	1,580,000.00	559,000.00	1,021,000.00	0.35
2107	Томилолт, зочны зардал	2,575,300.00	2,245,500.00	329,800.00	0.87
210702	Дотоод албан томилолт	2,575,300.00	2,245,500.00	329,800.00	0.87
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,858,000.00	16,067,510.00	1,790,490.00	0.90
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	16,774,000.00	15,445,800.00	1,328,200.00	0.92
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	228,000.00	228,000.00	-	1.00
210803	Даатгалын үйлчилгээ	214,000.00	163,350.00	50,650.00	0.76
210804	Тээврийн хэрэгслийн татвар	422,000.00	76,000.00	346,000.00	0.18
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	70,000.00	37,000.00	33,000.00	0.53
210807	Газрын төлбөр	150,000.00	117,360.00	32,640.00	0.78
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	5,000,000.00	-	1.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	5,000,000.00	-	1.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	800,000.00	800,000.00	-	1.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	800,000.00	800,000.00	-	1.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	800,000.00	-	1.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	351,092,700.00	343,172,298.00	7,920,402.00	0.98

Иххэт сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	350,092,700.00	341,900,106.00	8,192,594.00	0.98
132001	Орон нутгийн төсвөөс	350,092,700.00	341,900,106.00	8,192,594.00	0.98
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,000,000.00	1,272,192.00	(272,192.00)	1.27
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000,000.00	1,272,192.00	(272,192.00)	1.27
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	1.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	24.00	20.00	4.00	0.83
620001	Удирдах ажилтан	6.00	6.00	-	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	10.00	8.00	2.00	0.80
620003	Үйлчлэх ажилтан	8.00	6.00	2.00	0.75
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	24.00	20.00	4.00	0.83
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	11.00	9.00	2.00	0.82
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8.00	6.00	2.00	0.75
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	5.00	5.00	-	1.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0	30,844,166.00	(30,844,166.00)
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0	30,844,166.00	(30,844,166.00)
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0	30,844,166.00	(30,844,166.00)
2104	Хангамж, бараа материалын зардал	0	3,324,094.00	(3,324,094.00)
210401	Бичиг хэрэг	0	55,000.00	(55,000.00)
210402	Тээвэр, шатахуун	0	3,169,094.00	(3,169,094.00)
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	0	100,000.00	(100,000.00)
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0	939,000.00	(939,000.00)
210601	Багаж, техник, хэрэгсэл	0	939,000.00	(939,000.00)
2107	Томиллолт, зочны зардал	0	640,000.00	(640,000.00)
210702	Дотоод албан томиллолт	0	640,000.00	(640,000.00)
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0	25,941,072.00	(25,941,072.00)
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0	25,941,072.00	(25,941,072.00)
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0	2,400,000.00	(2,400,000.00)
	Дотоод эх үүсвэрээр	0	2,400,000.00	(2,400,000.00)
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0	49,491,539.00	(49,491,539.00)
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0	49,491,539.00	(49,491,539.00)

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Иххэт сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Н.Гантогтох танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021.02.09-өөс 2021.02.11–ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021.02.25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, ахлах аудитор Ч.Ариунаа хариуцаж хэрэгжүүлэв.

Иххэт сумын ЗДТГ нь 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг **Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт** 2021.01.22-ны өдрийн 05 дугаар бүхий албан бичгээр 2021.01.25-ны өдөр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ: Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн санал хүсэлтийг шийдвэрлэж төрийн үйлчилгээг хүргэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Иххэт сумын ЗДТГ нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас тайлант хугацаанд хяналт, шалгалт хийгдээгүй байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны хагас жилийн санхүүгийн тайлангийн СБТ дахь цэвэр хөрөнгийн дүн 1,618,959.5 мянган төгрөгийн 1 хувиар буюу 16,189.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд хэвээр тооцлоо.

Аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны цэвэр хөрөнгө 1,734,481.8 мянган төгрөгийн 1 хувиар буюу 17,344.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Иххэт сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 138,703.8 мянган төгрөгөөр буюу 8,7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	14,434.7	19,700.4	5,265.7
Бараа материал	25,675.6	33,233.8	7,558.2
Үндсэн хөрөнгө	1,555,692.7	1,681,572.7	125,880.0
Нийт хөрөнгө	1,595,803.0	1,734,506.8	138,703.8
Өр төлбөр	0.0	25.0	25.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,595,803.0	1,734,481.8	138,678.8
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,595,803.0	1,734,506.8	138,703.8

Авлага дансны үлдэгдэл 19,700.4 мянган төгрөг болж өссөн нь нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэл 16,247.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн, бараа материал худалдан авах тооцооны 3,453.0 мянган төгрөгийн авлага нэмэгдсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 33,233.8 мянган төгрөг болж 7,558.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь аж ахуйн материал, бусад хангамжийн материалын үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,681,572.7 мянган төгрөг болж 125,880.0 мянган төгрөгөөр өссөн байна. Үндсэн хөрөнгийн дансанд ОНТ-ийн хөрөнгө оруулалтаар 261,165.9 мянган төгрөг, урсгал төсвийн худалдан авалтаар 9,507.0 мянган төгрөг тус тус нэмэгдэж, тайлант хугацааны элэгдлийн зардалд 144,793.0 мянган төгрөгийг бүртгэж хассан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,734,481.8 мянган төгрөг болж 138,703.8 төгрөгөөр өсөхөд тайлант оны үр дүн нөлөөлжээ.

Иххэт сумын ЗДТГ-ын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 29,554.7 мянган төгрөгөөр буурч, 655,489.8 мянган төгрөг байна.

Нийт зардал өмнөх оноос 4,903.7 мянган төгрөгөөр буюу 1,3 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс, түлш халаалт, БГБНАУТХ-ийн зардал байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 343,317.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 343,317.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 7,775.7 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 351,092.7 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 351,092.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 350,092.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 1,000.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 341,900.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлого 1,272.2 мянган төгрөг, нийт 343,172.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 343,172.3 мянган төгрөгийг зарцуулж, 651.6 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 343,172.3 мянган төгрөг буюу 97,7 хувьтай байгаа нь орон нутгийн төсвөөс 8,192.6 мянган төгрөгийн санхүүжилт дутуу олгосонтой холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус дансанд 49,491.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, 33,244.1 мянган төгрөгийг зарцуулан, үлдэгдэл 16,247.4 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаа болоогүй 2 мэдээлэл, бусад 147 мэдээллийг хугацаанд нь оруулсан байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгч бүрэн хэрэгжсэн байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	-	2	-	-		
Нийт дүн	2		2		-		

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 27,027.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 20,488.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 5550.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 989.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай 20,488.2 мянган төгрөгийн дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Тайлант онд нийт 2,261.8 мянган төгрөгийн түрээсийн орлого төвлөрсөн бөгөөд үүнээс түрээсийн орлогын 50 хувь болох 25.0 мянган төгрөгийг орон нутгийн дансанд дутуу төвлөрүүлснийг өглөгийн дансанд бүртгүүлж залруулсан.
2. Нэмэлт санхүүжилтийн авлага 14,434.6 мянган төгрөгийг тайлант оны авлагаар хүлээн зөвшөөрч бүртгэснийг үр дүнгийн тайланд залруулсан.
3. Бараа материалын шинжтэй 2,189.6 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэснийг залруулсан.
4. Цалингийн урьдчилгаа 3,620.0 мянган төгрөгийг олгоходоо цалингийн өглөг дансанд буруу бүртгэснийг залруулсан.
5. Нэмэлт санхүүжилтийн данснаас зарцуулсан 219.0 мянган төгрөгийн шатахууны зардлыг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд бүртгэснийг залруулсан.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

1. Бүрдэнэ багийн даргын өрөөг Хөх бишрэлт ХХК-ний үнэ төлбөргүй хандивласан 1,950.0 мянган төгрөгийн материалаар засварлаж, тохижуулсан.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

2. Нэр бүхий 3 аж ахуйн нэгжээс хамтран ажиллах гэрээний санхүүжилт нэрээр нөхөн сэргээлтийн зардал 3,600.0 мянган төгрөгийг нөхөн сэргээлтийн санд байршуулахгүй, нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, гар аргаар олборлолт хийсэн газрыг нөхөн сэргээхэд зарцуулсан.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 989.6 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

4.1 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа

4.1.1 Илрүүлэлт:

Түрээсийн орлогын 989.6 мянган төгрөгийг бууруулах бичилт хийж, мөнгөн гүйлгээний тайлангийн орлогыг буруу илэрхийлсэн.

4.1.2 Эрсдэл

Энэ нь үнэн зөв байдал батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 2.14 дэх заалтыг зөрчсөн байна.

4.1.3 Зөвлөмж

Мөнгөн гүйлгээний тайланд түрээсийн орлогыг бүрэн бүртгэж, тайлагнаж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Иххэт сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			ДГА-2021/40/СТА- ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Иххэт сумын ЗДТГ		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгуул-лагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	5
1	Түрээсийн орлогыг бууруулах бичилт хийж, мөнгөн гүйлгээний тайлангийн орлогыг буруу илэрхийлсэн.	989.6	Зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	Т.Алтантуяа
2	Бүрдэнэ багийн даргын өрөөг Хөх бишрэлт ХХК-ний үнэ төлбөргүй хандивласан материалаар засварлаж, тохижуулсан.	1,950.0	Албан шаардлага өгөх	Сумын ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч	Н.Гантогтох, Т.Алтантуяа
3	Нэр бүхий 3 аж ахуйн нэгжээс хамтран ажиллах гэрээний санхүүжилт нэрээр нөхөн сэргээлтийн зардлыг авахдаа нөхөн сэргээлтийн санд байршуулахгүй, нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, гар аргаар олборлолт хийсэн газрыг нөхөн сэргээхэд зарцуулсан.	3,600.0	Албан шаардлага өгөх	Сумын ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч	Н.Гантогтох, Т.Алтантуяа
4	Тайлант онд нийт 2,261.8 мянган төгрөгийн түрээсийн орлого төвлөрсөн бөгөөд үүнээс түрээсийн орлогын 50 хувь болох 25.0 мянган төгрөгийг орон нутгийн дансанд дутуу төвлөрүүлснийг өглөгийн дансанд бүртгүүлж залруулсан.	25.0	Залруулга	Нягтлан бодогч	Т.Алтантуяа
5	Нэмэлт санхүүжилтийн авлага 14,434.6 мянган төгрөгийг тайлант оны авлагаар хүлээн зөвшөөрч бүртгэснийг үр дүнгийн тайланд залруулсан.	14,434.6	Залруулга	Нягтлан бодогч	Т.Алтантуяа
6	Бараа материалын шинжтэй 2,189.6 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэснийг залруулсан.	2,189.6	Залруулга	Нягтлан бодогч	Т.Алтантуяа
7	Цалингийн урьдчилгаа 3,620.0 мянган төгрөгийг олгохдоо цалингийн өглөг дансанд буруу бүртгэснийг залруулсан.	3,620.0	Залруулга	Нягтлан бодогч	Т.Алтантуяа
8	Нэмэлт санхүүжилтийн данснаас зарцуулсан 219.0 мянган төгрөгийн шатахууны зардлыг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд бүртгэснийг залруулсан	219.0	Залруулга	Нягтлан бодогч	Т.Алтантуяа
ДҮН		27,027.8			